



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/102

Бүрэн сум

Мал, амьтны сэг зэм устгах,
халдваргүйтгэл хийх, ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалт, Төв аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/153 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв суурин газар, малын бэлчээр, гол, горхи, булаг шандын орчимд мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулан устгах, халдварт өвчний голомт, устгалын цэгийг халдваргүйтгэх ажлыг зохион байгуулсугай.

2.Мал, амьтны сэг зэмийг устгах халдваргүйтгэлийн ажилд шаардагдах ажиллах хүн хүч, тээврийн хэрэгсэл, шатахуун болон шаардлагатай бусад зардлыг шийдвэрлэж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч (Б.Отгоншигт)-д даалгасугай.

3.Халдваргүйтгэл хийхэд шаардагдах халдваргүйтгэлийн бодисоор хангаж, сэг зэм устгал, халдваргүйтгэлийн бодисын зарцуулалтын тайлан, мэдээг гаргах, халдваргүйтгэлийн ажилд явцын болон гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Н.Хүрэлбаатар)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Пүрэв-Очир)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.ТҮВШИНБАТ



412305228